



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 12-дээр

Дугаар 04

Улаанбаатар хот

### “Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолын хавсралтад “эрх бүхий байгууллагын шийдвэрээр гүйцэтгэх аудит” гэсэн хэсэг нэмж, мөн хэсэгт “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон Тавантолгойн орд ашиглалтад төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулиар хүлээсэн үргийн биелэлт” гэсэн аудитын сэдвийг, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх хугацааг 2020.12.15, хэлэлцүүлэх Байнгын хороог “Эдийн засгийн байнгын хороо” гэж, мөн хэсэгт “Засгийн газраас агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр 2017-2020 онд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр нөлөө” гэсэн аудитын сэдвийг, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх хугацааг 2021.04.15, хэлэлцүүлэх Байнгын хороог “Төсвийн байнгын хороо” гэж, мөн хэсэгт “Монголын үндэсний олимпын хорооны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын үр дүн” гэсэн аудитын сэдвүүдийг тус тус нэмэх.

2.“Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолын хавсралтад “өмнөх оноос шилжиж буй аудит” гэсэн хэсэг нэмж, мөн хэсэгт “Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт- /Доншен газрын тос (Монгол) ХХК, 2015-2018/” гэсэн аудитын сэдвийг, тайланг Улсын Их Хуралд хүргүүлэх хугацааг 2020.11.30, хэлэлцүүлэх Байнгын хороог “Эдийн засгийн байнгын хороо” гэж нэмэх.

3.“Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолын хавсралтын “хуулийн дагуу гүйцэтгэх аудит” гэсэн хэсгийн 17 дугаарт тусгагдсан “Газрын тосны салбарт 2019 онд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолтын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалт” гэсэн аудитын сэдвийн Улсын Их Хуралд хүргүүлэх хугацааг “2020.06.15” гэснийг “2020.12.30” гэж, “он дамжиж гүйцэтгэх аудит” гэсэн хэсгийн 31 дүгээрт тусгагдсан “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, түүний төслийн үр өгөөжид үзүүлэх нөлөөлөл”-д хийх аудитын сэдвийн нэрийг “Оюутолгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт,

санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө” гэж, Улсын Их Хуралд хүргүүлэх хугацааг “2020.05.15” гэснийг “2021.12.30” гэж тус тус өөрчлөх.

4. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудын шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотой 2020 оны сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан хийх аудитын сэдэвт хуулийн заалтад нийцүүлэн өөрчлөлт оруулах.

5. “Аудитын сэдэв батлах тухай” Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолын хавсралтын “хуулийн дагуу гүйцэтгэх аудит” гэсэн хэсгийн 19 дүгээрт тусгагдсан “Тухайн жилд хэрэгжиж эхлэх төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагаанд аудит хийх” сэдвийг, мөн хэсгийн 27 дугаарт тусгагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох” сэдвийг, мөн хэсгийн 29 дүгээрт тусгагдсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” сэдвүүдийг тус тус хасах.

6. Энэ тогтоолын хэрэгжилтийг ханган, аудитыг батлагдсан цаг хугацаанд нь чанарын өндөр төвшинд хийж гүйцэтгэх, гүйцэтгэсэн аудитын тайланг Улсын Их Хурлын Байнгын хороо, гишүүдэд хүргүүлж байхыг Үндэсний аудитын газар /Д.Занданбат/-т үүрэг болгосугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Б.ЧОЙЖИЛСҮРЭН